

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт –
- 2019 оны 12 дугаар сарын 27- ны байдлаар**

Нэгдүгээр зорилго: ОУИТБС-ын стандартад заасан санхүүгийн бус мэдээллийг төрийн байгууллагын системээр тогтмол ил тод болгох ажлыг хэвшүүлэх, тогтвортой байдлыг хангах							
Үндэслэл: ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас Монгол Улсад дээрх зөвлөмжийг хүргүүлээд буй. Гол ач холбогдол нь Хараат бус хянагч, нэгтгэгчийн ажлын цар хүрээг багасгах, зардлыг бууруулах, тооноос чанар руу шилжих боломжийг олгох, төрийн байгууллагууд ил тод байдлыг үйл ажиллагаандаа хэвшүүлэх, улмаар хариуцлагатай байдлыг сайжруулахад оршино. Иймд шилжүүлэн хэвшүүлэхтэй холбоотой ажлуудыг энд төлөвлөсөн болно.							
Зохицуулах байгууллага: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам							
ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН	ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА	ХУГАЦАА	ТӨСӨВ /ГҮЙЦЭТГЭЛ		
					мян. төг	Эх үүсвэр	Гүйцэтгэл
Зорилт 1. Хэвшүүлэн ил тод болгох шаардлагатай мэдээллийн сангуудыг бий болгох, сайжруулах;	1.1 Кадастрын системд шаардлагатай өөрчлөлтийг оруулж ОУИТБС-ын стандартаар шаардсан өргөдлийн огноо, БХГ-ий талбайн солбилцол, сонгон шалгаруулалтын бүх дүн зэрэг мэдээллийг ил тод болгох боломжийг бүрдүүлэх	Тусгай зөвшөөрлийн бүртгэл, олголттой холбоотой стандартаар шаардсан бүх мэдээлэл ил тод болсон байна	АМГТГ	1-6-р сар	10,000	Хандивлагч	Хэрэгжээгүй, 2020 онруу шилжүүлсэн.
	1.2 Цахим тайлагналын системд шаардлагатай нэмэлтийг хийж төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн маягт, тээврийн маягтын дагуу тайлан хүлээн авах, нийтэд мэдээлэх;	Стандартаар шаардсан төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй холбоотой мэдээлэл ил тод болсон байна.	УУХҮЯ	3-6-р сар	10,000	Хандивлагч	Хэрэгжээгүй, 2020 онруу шилжүүлсэн.
	1.3 ОУИТБС-ын вэб хуудсанд нэмэлт өөрчлөлт хийж төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны хүрээнд ил тод болж буй мэдээллүүдийг нэг цэгээс авах боломж бүрдүүлэх;	Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны хүрээнд ил тод болсон мэдээлэлд нэг цэгээс хандах боломж бүрдсэн байна.					Хандивлагч

	1.4 Гэрээний ил тод байдлын програмд нэмэлт өөрчлөлт хийж орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон төрийн байгууллагууд эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компанитай байгуулсан гэрээгээ оруулах, холбогдох тайлбаруудыг оруулж өгөх;	Эрдэс баялгийн салбарт байгуулсан бүх гэрээг ил тод болгон мэдээлэл боломж бүрдсэн байна.	УУХҮЯ, ННФ	6-9-р сар	15,000	Хандивлагч	Хэрэгжсэн.4-р сард 426 гэрээ ил тод болсон.
Зорилт 2. Хэвшүүлэн ил тод болгох талаар төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, чадавхийг бэхжүүлэх;	2.1 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд зориулсан сургалт зохион байгуулах;	ОУИТБС-ын стандартад заасан санхүүгийн бус мэдээллүүд төрийн байгууллагуудын цахим хуудсаар тогтмол ил тод болох чадавх бэхжсэн байна.	Эрдэнэс Монгол ХХК, ТӨБЗГ, Ажлын алба	2- р сар	500	Хандивлагч	Хэрэгжээгүй. 2020 онруу шилжүүлсэн.
	2.2 Сангийн яам, ТЕГ, ГЕГ-ын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах;		Сангийн яам, Ажлын алба	3- р сар	500	Хандивлагч	Хэрэгжсэн, 10-р сарын 25-нд ТЕГ- т сургалт зохион байгуулсан.
	2.3 НДЕГ, ХХҮГ-ын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах;		Ажлын алба	4- р сар	500	Хандивлагч	Хэрэгжээгүй. 2020 онруу шилжүүлэх
	2.4 УУХҮЯ, АМГТГ-ын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах		УУХҮЯ, Ажлын алба	1-р сар	500	Хандивлагч	Хэрэгжээгүй. 2020 онруу шилжүүлсэн.
	2.5 Орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах;		Ажлын алба, ЗГХЭГ	5-р сар	20,000	Хандивлагч	Хэрэгжсэн. Орон нутгийн гэрээг Гэрээний сайтад оруулах холбогдох сургалт 4-р сард хийгдсэн.
Нэгдүгээр зорилтын дүн					37,000		

Хоёрдугаар зорилго: Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг дахин боловсруулж, УИХ-аар батлуулах
Үндэслэл: Монгол Улс 2018 оны 2-р сард дэлхий дахинаа ОУИТБС-ын стандартыг бүрэн хангасан хоёрдогч орноор тунхаглагдсан билээ. Гэсэн хэдий ч 2020 оны 1 сарын 1-нээс эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ашиг хүртэгч эцсийн эздийг ил тод болгох, гэрээний ил тод байдлыг бүрэн хангах, авилгалын эрсдэлийг бууруулах, төрийн байгууллагуудын системээр санхүүгийн бус мэдээллийг тогтмол ил тод болгох зэрэг томоохон зорилтуудыг хангах шаардлага байсаар байна. 2007-2018 оныг дуустал 12 жилийн хугацаанд Монгол Улсад ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлэхэд хандивлагч орнууд Дэлхийн банкаар дамжуулан үйл ажиллагааг санхүүжүүлэн буцалтгүй тусламжийг үзүүлж ирсэн ч цаашид тэдний зүгээс ОУИТБС-ыг Монгол Улсын Засгийн газар манлайлан авч явж, өөриймшүүлэх нь зүйтэй гэж үзэн 2019 оноос эхлэн санхүүжилтээ зогсоохоо мэдэгдээд байна. Иймд цаашид урт хугацаанд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд санхүүгийн болон институтын тогтвортой байдлыг хангах, үр нөлөөг улам нэмэгдүүлэх үүднээс бие даасан хуулийн төсөл дахин боловсруулж, батлуулах зорилтыг тавьж, холбогдох үйл ажиллагаануудыг энд тусгалаа.

Зохицуулах байгууллага: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам							
ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН	ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦ АА	ТӨСӨВ /ГҮЙЦЭТГЭЛ		
					мян. төг	Эх үүсвэр	Гүйцэтгэл
Зорилт 3: Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах, УИХ-д өргөн барих	3.1 Хуулийн ажлын хэсэг байгуулах	Бие даасан хуультай болж, эрх зүйн орчин тодорхой болно.	УУХҮЯ	1-р сар	-	-	Хэрэгжсэн, Хуулийн ажлын хэсэг байгуулсан
	3.2 Шаардлагатай судалгаануудыг хийж, үзэл баримтлалаа боловсруулах		УУХҮЯ, Хуулийн ажлын хэсэг, Ажлын алба	2-4-р сар	10,000	Хандивлагч	Хэрэгжиж байна.
	3.3 Хуулийн төсөл боловсруулах, оролцогч талуудаар хэлэлцүүлэх		Ажлын алба, Хуулийн ажлын хэсэг	4-6-р сар	8,000	Хандивлагч	Хэрэгжиж байна.
	3.4 Хуулийн төслийг УИХ-д өргөн барих		УУХҮЯ	9-р сар	-	-	Хэрэгжээгүй, 2020 онруу шилжүүлсэн.
	3.5 Хуулийн ач холбогдлыг танилцуулан сурталчлах		Ажлын алба, УУХҮЯ	9-р сард	6-10-р сар	Хандивлагч	Хэрэгжиж байна.
Хоёрдугаар зорилт дүн					48,000		
Гуравдугаар зорилго: Ашиг хүртэгч эцсийн эздийн ил тод байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, бүртгэлийн тогтолцоог сайжруулах, туршилтаар мэдээлэл цуглуулах							
<p>Үндэслэл: ОУИТБС-ын Үндэсний зөвлөлөөс баталсан Замын зургийн дагуу 2019 онд төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлнэ. Санхүүжилтыг ЕСБХБ/ОУИТБС-ын ОУНБДНГ- аас гаргуулахаар төлөвлөв. 2018 онд энэ хүрээнд УИХ, Засгийн газар, бусад оролцогч талуудын дунд өндөр түвшний дугуй ширээний уулзалтуудыг зохион байгуулж, ИНБ, сэтгүүлчдийн чадавх бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулсан билээ. 2017 оны нэгтгэл тайлангаар 184 аж ахуйн нэгж өөрсдийн эзэмшлийн мэдээллээ сайн дураар ил тод болгоод буй. Ажлын албанд хуульчийн орон тоо бий болгож, холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулаад буй. 2018 оны 11 сараас эхлэн Улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсны дагуу Монгол улсад бүртгэлтэй бүх хуулийн этгээдүүдийн хувь эзэмшигчдын мэдээлэл олон нийтэд ил тод болсон. Гэсэн хэдий ч тус мэдээллийг цуглуулж буй төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, ашиг хүртэгч эцсийн эзэн мөн эсэхийг баталгаажуулах, цахим системийг сайжруулах, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрэн сурвалжлах сэтгүүл зүй, ИНБ-ын чадавхийг үргэлжлүүлэн бэхжүүлэх зэрэг Замын зурагт тусгасан үлдсэн ажлуудыг 2019 онд хэрэгжүүлэх шаардлага бий. Иймд эдгээр ажлуудыг энэ хэсэгт тусгасан болно.</p>							
Зохицуулах байгууллага: Засгийн газрын Хэрэг эрхлэх Газар/Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам							
ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН			ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ		

			ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦАА	мян. төг	Эх үүсвэр	Гүйцэтгэл
Зорилт 4: ОУИТБС-ын 2013-2017 оны тайлангаар ил болсон ашиг хүртэгч эцсийн эздийн мэдээллийн ашиглан нөлөөллийн ажил зохион байгуулах	4.1 Иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн багтай хамтран кэйсүүд дээр ажиллах, олон нийтэд сурталчлах.	АХЭ-ийн ил тод байдлын ач холбогдлыг бодит жишээ дээр ойлгож, олон нийтийн дэмжлэгийг авна	ОУИТБС-ын ОУнбд нарын газар, ТАН эвсэл	2-6 сар	15,000 евро	ЕСБХБ	Транспаренси Интернейшнлтэй хамтарч, зөвлөлдөх уулзалтыг 2, 5-р сард зохион байгуулсан.
	4.2 Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн чадавхийг бэхжүүлэх	Чадавх бэхжсэн байна.	Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төв, Ажлын алба	2-6 сар			Хэрэгжээгүй байна.
	4.3 АХЭ цахим сайтыг баяжуулах, дэмжлэг үзүүлэх	Мэдээллийн сангийн ашиглалт нэмэгдсэн байна.	Ил тод байдал сан ТББ, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Ажлын алба	1-6 сар	20,000	ББЗХ EBRD	Хэрэгжээгүй байна.
	4.4 Засгийн газрын байгууллагуудын Ажлын хэсгийг байгуулан, зохицуулалтаар хангах	Бүрэн хэрэгжих бололцоог хангасан байна.	ЗГХЭГ/ УУХҮЯ	1-12 сар	1,000	ЗГХЭГ	Хэрэгжээгүй, 2020 онруу шилжүүлсэн.
Зорилт 5: Ашиг хүртэгч эздийн мэдээллийг цуглуулах системийг хөгжүүлэх, мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаажуулах институтыг бэхжүүлэх	5.1 УБЕГ, ТЕГ-тай хамтран чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах	Төрийн байгууллагын чадавх бэхжсэн байна.	Ажлын алба	8-р сард	40,000 евро	EBRD	Хэрэгжсэн.
	5.2 АХЭ-ийн мэдээллийг бүртгэдэг, хүлээн авдаг төрийн байгууллагуудын системийг боловсронгуй болгож, нэгтгэх, мэдээлэл солилцоог сайжруулах	Мэдээлэл цуглуулах, солилцох механизм боловсронгуй болсон байна.	Зөвлөх компани	8р сар			Хэрэгжээгүй, 2020 онруу шилжүүлсэн.
	5.3 Холбогдох журам, маяганд өөрчлөлт оруулах	Холбогдох журам, маяганд өөрчлөлт оруулсан байна.	ОУИТБС Үндэсний зөвлөл	7-10 сар			Хэрэгжээгүй, 2020 онруу шилжүүлсэн.
	5.4 Шинэчилсэн журам, маягыг олон нийтэд сурталчилах	Зорилтот бүлэг мэдээлэл авсан байна.	Ажлын алба	10-12 сар			Хэрэгжээгүй, 2020 онруу шилжүүлсэн.
Гуравдугаар зорилтын дүн					55,000 евро 21,000 төг		

Дөрөвдүгээр зорилго: Монгол Улсын ОУИТБС-ын 2018 оны тайлангийн нэгтгэлийн явцыг сайжруулах, тайланг хэлэлцэн батлах

Үндэслэл: Тогтмол ажил, Хараат бус хянагч, нэгтгэгчийг эрт сонгон шалгаруулах, Ажлын даалгаврыг хэлэлцэн батлах, Эхлэлтийн семинарыг үр дүнтэй зохион байгуулж, чанартай тайлан боловсруулах, тайлангийн ирцийг нэмэгдүүлэх, анхлан тайлагналыг зөрүүг буруулахад чиглэсэн ажлууд энд багтана.

Зохицуулах байгууллага: Ажлын алба

ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН	ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦАА	ТӨСӨВ /ГҮЙЦЭТГЭЛ		
					мян. төг	Эх үүсвэр	Гүйцэтгэл
Зорилт 6: Нэгтгэл тайланг боловсруулах, батлах	6.1 Нэгтгэл тайланг боловсруулах Хараат бус хянагч, нэгтгэгчийг сонгон шалгаруулах, Ажлын даалгаврыг батлах, гэрээлэх	Хараат бус хянагч, нэгтгэгчийг эрт сонгон шалгаруулсан байна.	Үнэлгээний хороо, Ажлын хэсэг	1-3 сар	-	-	Хэрэгжсэн
	6.2 Эхлэлтийн семинарыг зохион байгуулж, 2018 оны тайлангийн маягыг батлах	Тайлангийн цар хүрээ тодорхойлогдсон байна.	ХБХН, Ажлын хэсэг	4-5 сар	-	-	Хэрэгжсэн
	6.3 2018 оны тайланг цахимаар хүлээн авах, шаардлагатай заавар зөвлөмжийг өгөх, гарын авлагыг сайжруулах, сурталчилах	Тайлангийн ирц сайжирч, анхны зөрүү 10%-иар буурсан байна.	Ажлын алба, УУХҮЯ	1-6 сар	-	-	Хэрэгжсэн
	6.4 2018 оны нэгтгэл хамрагдсан компаниудад 3 удаагийн сургалт зохион байгуулах, тайлангийн ач холбогдлыг таниулан ойлгуулах	Нэгтгэлийн явцад үүсэх хүндрэлүүд багассан байна, компаниудын мэдээллийн баталгаажуулалт сайжирсан байна.	ХБХН, Ажлын алба	6-7 сар	-	-	Хэрэгжээгүй.
	6.5 Нэгтгэл тайланг боловсруулах, хэлэлцэх, батлах	Нэгтгэл тайланг 11-р сард багтаж баталсан байна.	ХБХН, Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл	8-11 сар	229,4 сая төг	Улсын төсөв	Хэрэгжиж байна. 196 сая төг- гэрээт зөвлөх Монгол Тунисын БДО консерцум
Дөрөвдүгээр зорилт дүн					254,4 Сая төг Гишүүний татвар 26 сая орчим нэмэгдэнэ		

Тавдугаар зорилго: Үндэсний болон орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлсний үр нөлөө, ач холбогдол, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, ашиг хүртэгч эцсийн эздийг зарлах зэрэг асуудлыг оролцогч талуудад таниулан сурталчлах, хамтын ажиллагааг сайжруулах

Үндэслэл: 2019 онд хэд хэдэн онцлох зорилтуудыг тавьсан. Үүнд, бие даасан хуулийн төслийг боловсруулж, батлуулах, төрийн байгууллагуудын системээр ОУИТБС-ын стандартаар шаардсан санхүүгийн бус мэдээллийг тогтмол мэдээлэх, ашиг хүртэгч эцсийн эздийг ил тод болгоход чиглэсэн бэлтгэл ажлуудыг хангах, тайлангаар ил

болсон мэдээллийн ашиглалтыг сайжруулах зэрэг томоохон цар хүрээтэй хамтын ажиллагаа, мэдээлэл, сурталчилгаа, харилцаа холбооны ажлыг шаардаж буй. Иймд дээрх зорилгуудад хүрэхэд чиглэсэн стратеги бүхий мэдээлэл, сурталчилгааны ажлуудыг үндэсний түвшинд болон орон нутгийн түвшинд үргэлжлүүлэн зохион байгуулахаар энд төлөвлөлөө.

Зохицуулах байгууллага: Ажлын алба

ЗОРИЛТУУД	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ҮР ДҮН	ХАРИУЦАХ ТАЛ	ХУГАЦ АА	ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ		
					(мян. төг)	Эх үүсвэр	Гүйцэтгэл
Зорилт 7. Үндэсний түвшний мэдээлэл харилцааг идэвхжүүлэх	7.1 Мэргэжлийн холбоодтой (МУУҮА, АХТ, АХТ, МҮХАҮТ, МБЗ, АҮХ) хамтын ажиллагааг өргөжүүлэх, 6 цуврал уулзалт семинар зохион байгуулах	Мэдлэг ойлголт нэмэгдэж, хуулийн төсөлд компаниудын саналыг авсан байна.	Мэргэжлийн холбоод, УУХҮЯ, Ажлын алба	3-12	6,000	Мэргэжлийн холбоод	Хэрэгжсэн. Монголын бизнесийн зөвлөлтэй хамтран Дисковер Монголиа хүрээнд уулзалт зохион байгуулсан.
	7.2 Ил тод уул уурхай хэвлэлийн бага хуралд сар бүр оролцож, үйл ажиллагааг сурталчлах	Олон нийт ОУИТБС-ын талаарх мэдлэг ойлголт нэмэгдэж, хуулийн ач холбогдлыг ойлгосон байна.	УУХҮЯ-ны Хэвлэлийн алба	Сар бүр	-	-	Хэрэгжсэн.
	7.3 Салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, бодлогын хүрээлэнгүүдтэй тогтмол уулзалтыг зохион байгуулж, санал солилцох-	Мэдлэг ойлголт нэмэгдэж, хуулийн төсөлд иргэний нийгэм, бодлогын хүрээлэнгүүдийн саналыг авсан байна.	ТАН эвсэл, Ажлын алба	Хоёр сар тутамд	6,000	Хандивлагч	Хэрэгжсэн. Транспаренси Интернейшнл, ББЗХ хамтарч АХЭ, Төслийн тайлагнал, Гэрээний ил тод байдлаар Олон талт оролцогчдын уулзалтыг хамтран зохион байгуулсан.
	7.4 УИХ-ын Эдийн засаг, Төсвийн байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд Монгол Улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтийн үр нөлөө, ач холбогдол, цаашдын зорилтыг танилцуулах	Гишүүдийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна.	Үндэсний зөвлөл	5-р сар	-	-	Хариуцлагатай УУ-н лоббийн төлөөлөл УИХ-ын гишүүн Ундраад бараалхаж ажлуудаа танилцуулсан. Хэрэгжсэн.
	7.5 ОУИТБС-ын 8-р бага хуралд оролцох	Олон улс дахь хэрэгжилтийн талаар мэдээлэл авч, Үндэсний зорилго, зорилтоо бататгасан байна.	ОУ-ын нарийн бичгийн дарга нарын газар, Ажлын алба	6-р сар	15,000	Хандивлагч	Хэрэгжсэн. Нийт 6 төлөөлөгч оролцсон

	7.6 Хууль өргөн барихтай холбоотойгоор богино хугацааны мэдээлэл, харилцааны идэвхжүүлэлт	Хууль тогтоох байгууллагын мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна.	УУХҮЯ, Ажлын алба, Зөвлөх компани	Идэвх-жүүлэлт	100,000	Хандив-лагч	Хэрэгжиж байна. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн ач холбогдлын талаар Майнинг сэтгүүлд УУХҮСайдын ярилцлага хэвлүүлсэн.
	7.7 Олон улсын үзэсгэлэн, сургалт, уулзалтуудад зориулсан хэвлэлтийн ажлууд	Тараах материалууд бэлэн болсон байна	Ажлын алба	2-5-р сар	20,000	Хандив-лагч	Хэрэгжиж байна. Үлдсэн хугацаанд 2018 оны тайлан, шинэ стандартыг хэвлүүлнэ.
	7.8 Бусад тогтмол хэрэгжүүлэх мэдээлэл, сурталчилгааны ажлууд-	Олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдэх	Ажлын алба	1-12-р сар	10,000	Хандив-лагч	Хэрэгжиж байна. Хариуцлагатай уул уурхайн өдөрлөгт оролцож мэдээлэл, материал түгээсэн, Майнинг сэтгүүлд ярилцлага хэвлүүлсэн.
Зорилт 8: Орон нутгийн түвшин дэх мэдээлэл харилцааны ажлуудыг үргэлжлүүлэх	8.1 Төвийн бүсийн III зөвлөгөөн – Булган аймаг (5 аймаг, 100 хүн)	Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхжсэн байна.	Ажлын алба	8 сар	30,000	Хандив-лагч	Хэрэгжээгүй, 2020 онруу шилжүүлсэн.
	8.2 Зүүн бүсийн II зөвлөгөөн – Сүхбаатар аймаг /3 аймаг, 100 хүн/	Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхжсэн байна.	Ажлын алба	9 сар	25,000	Хандив-лагч EBRD	Хэрэгжсэн, Дорнод аймагт УУХҮЯ, Мерит, ОУСК-тай хамтран зохион байгуулсан
	8.3 Жишиг сумдын үйл ажиллагааг үргэлжлүүлэн идэвхжүүлэх	Засаглал сайжирсан байна	Иргэний нийгмийн эвсэл, Ажлын алба	сар	50,000	Хандив-лагч	Хэрэгжээгүй.
	9.5 Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих /4 гэрээ/	Гэрээний ил тод байдлын үр нөлөө бодитоор дээшилсэн байна.	Иргэний нийгмийн эвсэл	9-10 сар	15,000	Хандив-лагч	Хэрэгжээгүй, 2020 онруу шилжүүлсэн.

	9.6 Дэд зөвлөлийн туршлага солилцох аялал /Ханбогд сум)	Бусад 3 сумын чадавх бэхжсэн байна	Өмнөговь дэд зөвлөл, Ажлын алба	9 сар	10,000	Хандивлагч	Хэрэгжээгүй.
Тавдугаар зорилтын дүн					145000		
НИЙТ ТӨЛӨВЛӨЛТ 419,9 сая төг						Зарцуулалт: Улсын төсөв 221 сая, ЕСБХБ 144,4 сая, АХБ-2,5 сая болов, бүгд 368,1 сая төг	
Нийт 40 үйл ажиллагаа төлөвлөснөөс Хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа нь 20 буюу биелэлтийн 50% болж байна.						Хангалттай.	

ОУИТБС-ын ажлын алба